Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2.565.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оны ахмадын сангийн дансны үлдэгдэл 2.465.4 мянган төгрөг байсан бөгөөд оны эцэст ахмадын сангийн журмын дагуу 100.0 мянган төгрөгийг Төрийн сангийн 100030020501 тоот дансанд байршуулж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Авлагын дансны үлдэгдэл 3.066.9 мянган төгрөг байгаа нь 4, 5, 6 дугаар сард илүү мэдээлсэн шимтгэлийг залруулснаар 813.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэн, урд оны ХХОАТ-ын авлага 2.203.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулж тусгасан, суутгаагүй урьдчилгаа цалин 50.0 төгрөгийг санхүүгийн тайланд тус тус тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 140.776.2 мянган төгрөг болж 6.946.2 мянган төгрөгөөр буурч байна.

Төсвийн худалдан авалтаар 26.662.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 390.0 мянган төгрөгийн тусгай

зориулалтын материал, ЗӨСҮТ-ээс 125.0 төгрөгийн эм боох материал, "НИК" ХХК-аас гэрээний дагуу шатахууны урамшуулалд 247.8 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, нийт 762.8 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд 34.371.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1.345.919.3 мянган төгрөг болж 97.264.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 419.9 мянган төгрөгийн, Аймгийн Эрүүл мэндийн газраас 159.799.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд 28.2 мянган төгрөгийн өртөг бүхий барилга байгууламж, 15.200.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 32.241.5 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 5.213.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 10.271.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, нийт 62.955.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/08 тоот Хөрөнгө акталж, данснаас хасах тухай тогтоолоор 6.608.0 төгрөгийн, 13/10 тоот Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах тухай тогтоолоор 15.200.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар шилжүүлсэн, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/66 тоот Хөрөнгө акталж, данснаас хасах тухай тогтоолоор 41.147.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.619.4 мянган төгрөг байгаа нь тайлант онд гэрэл цахилгааны өглөг 1.219.4 мянган төгрөгөөр, шуудан холбооны өглөг 197.2 мянган төгрөгөөр, цалингийн өглөг 12.9 мянган төгрөгөөр тус тус үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1.260.078.4 мянган төгрөг болж 117.945.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 117.945.9 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 786.204.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 786.204.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 155.056.5 мянган төгрөгөөр бууруулж 631.147.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 631.147.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 629.956.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. 1.191.6 мянган төгрөг хэмнэсэн нь аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох 83.3 мянган төгрөг, даатгалын үйлчилгээ 210.7 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо 73.0 мянган төгрөг, газрын төлбөр 339.6 мянган төгрөг, дотоод албан томилолт 234.0 төгрөг, бусад бага дүнгээр хэмнэсэн зардлууд байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Дд | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|----|-------------------------------------|----------------|----------------|--------------|---------|
| 1 | 71601 Нийгмийн эрүүл мэнд | 631,147,700.00 | 629,956,088.87 | 1,191,611.13 | 99.8 |
| 2 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 630,619,000.00 | 629,491,088.87 | 1,127,911.13 | 100.0 |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 528,700.00 | 465,000.00 | 63,700.00 | 88.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд шатахууны зардалд нийт 8.798.8 мянган төгрөг батлагдсанаас “НИК” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 31.975.0 мянга, гэрэл цахилгааны зардалд 2.682.3 мянга, цэвэр бохир усны зардалд 1.761.3 мянган төгрөг батлагдсанаас “Тахилгат дулаан цагаан хайрхан” ХХК, “Чандмань-Баянхонгор” ХК-иудтай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээ, “Чандмань-Баянхонгор” ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 170 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны зардлын дүн 457.886.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.868.1 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.151.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь ЗӨСҮТ, аймгийн ЭМГ-аас ирүүлсэн чиглэлийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 631.104.1 мянган төгрөгийн 12 мэдээлэл, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 27.258.0 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 6.4.5

“Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 11.867.7 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 11.867.7 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг аудитын явцад нөхөж мэдээлсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, аудитаар 10.021.3 мянган төгрөгийн 6 зөвлөмж, 168.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 168.1 | 1 | 168.1 | 100% |
| Албан шаардлага | - | - | - | - | - |
| Зөвлөмж | 6 | 10.021.3 | 6 | 10.021.3 | 100% |
| Нийт дүн | 7 | 10.189.5 | 7 | 10.189.5 | 100% |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал: Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 11.867.7 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Шилэн дансны цахим сайтад нийт 11.867.7 мянган төгрөгийн 2 ширхэг “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ”-г мэдээлээгүй орхисон нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж, мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. 2023 оны санхүүгийн тайланд Нийгмийн даатгалын байгууллагаас 813.9 мянган төгрөгийн шимтгэлийн авлага, Татварын хэлтсээс 2.203.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагатай гарсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь “Дансны

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” заалт, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 9.548.3 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс 3.280.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,619,4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 4.648.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 6.481.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 386.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын даргын 2023 оны 07 дугаар сарын 20-ны А/30 дугаар тушаалаар байгууллагын жижүүр П.Хүчитбаатарт сахилгын шийтгэл ноогдуулсан байхад 2023 оны 07 дугаар сарын 24-нд үр дүнгийн урамшуулал 213.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагчаар 213.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.1.2 2023 оны 1-7 дугаар саруудад 6 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн дүнгээс илүү мэдээлснийг 11 дүгээр сард залруулсны улмаас Нийгмийн даатгалын байгууллагаас 813.9 мянган төгрөгийн шимтгэлийн авлагатай, 2022 оны ХХОАТ-ын тооцооллоос үүссэн 2.203.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаснаар 3.067.0 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 3.067.0 мянган төгрөгийн авлагыг холбогдох байгууллагуудаас суутган тооцож, буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны зардлаас 1.619.4 мянган төгрөгийн өглөг үүссэн нь байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.2.2 дахь заалт “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн, баталж хэрэгжүүлэх”, 6.4.8 дахь заалт “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийг бодитой төлөвлөх, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж³

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагатай 2023 онд “Дулаанаар хангах гэрээ”-гээр хамтран ажиллаж байсан “Тахилгат дулаан цагаан хайрхан” ХХК нь 2023 оны 4, 5 дугаар саруудад гэрээний 2.1 дэх заалт “Стандартын шаардлагад нийцсэн дулаан эрчим хүчээр хэрэглэгчийг хангах” заалтыг хэрэгжүүлээгүй байхад халаалтын зардлыг бүрэн шилжүүлсэн зөрчил илэрсэн.

Энэ нь тухайн “Тахилгат дулаан цагаан хайрхан” ХХК-тай тухайн үед дулаанаар хангах гэрээгээр хамтран ажиллаж байсан Мал эмнэлгийн газар болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын өглөг, авлагын журнал, Зоонозын өвчин судлалын төвийн тогтмол зардлын түүвэр болон цахилгааны зардлын 1.219.4 мянган төгрөгийн өр үүссэнээр нотлогдсон.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2 “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” заалтыг хэрэгжүүлж ажиллах, мөн харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--|-------------|---------|--------------------|---------|------------------------|---------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2023 оны 7 дугаар сарын 20-нд байгууллагын даргын А/30 тушаалаар жижүүр П.Хүчитбаатарт сахилгын шийтгэл ноогдуулсан байхад 2023.07.24-нд үр дүнгийн урамшуулал олгосон байна. | 1 | 213.0 | 1 | 213.0 | | | | |
| 2023 оны санхүүгийн тайланд Нийгмийн даатгалын байгууллагаас 813.9 мянган төгрөгийн шимтгэлийн авлага, Татварын хэлтсээс 2.203.0 төгрөгийн ХХОАТ-ын авлагатай гарсан нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь заалт “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” заалтыг зөрчсөн байна. | 1 | 3.067.0 | 1 | 3.067.0 | | | | |
| Тайлант онд гэрэл цахилгааны өглөг 1.219.4 мянган төгрөг, шуудан холбооны өглөг 197.2 мянган төгрөг, цалингийн өглөг 12.9 мянган төгрөгөөр тус тус үүсэж, үндсэн үйл ажиллагааны зардлыг хэтрүүлсэн байна. | 1 | 1.619.4 | | | 1 | 1.619.4 | | |

³ Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”

Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | | | | | |
|---|----------|----------------|----------|---------|---|---------|--|---|---------|
| 2023 онд "Тахилгат дулаан цагаан хайрхан" ХХК-тай дулаанаар хангах гэрээгээр хамтран ажиллаж байсан бөгөөд 2023 оны 4, 5 дугаар саруудад гэрээний 2.1 дэх "Стандартын шаардлагад нийцсэн дулаан эрчим хүчээр хэрэглэгчийг хангах" заалтыг хэрэгжүүлээгүй байхад халаалтын зардлыг бүрэн шилжүүлсэн байна. | 1 | 4.648.9 | | | | | | 1 | 4.648.9 |
| Нийт дүн | 4 | 9.548.3 | 2 | 3.280.0 | 1 | 1.619.4 | | 1 | 4.648.9 |

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 48/А0571212/БНА-2024/03/НА-СТА-ШЗ Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын жижүүр П.Хүчитбаатарт байгууллагын даргын 2023 оны 7 дугаар 20-ны А/30 тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулсан байхад 2023 оны 07 дугаар сарын 24-нд цалин олгохдоо үр дүнгийн урамшуулал 213,000 (Хоёр зуун арван гурван мянган төгрөг)-ийг бодож олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ноогдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрхзүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 дахь “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү бодож олгосон 213,000 (Хоёр зуун арван гурван мянган төгрөг)-ийг төсөв захирагчаар төлүүлж Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

5050200

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын төвийн дарга Б.Алтанчимэг, нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ нарт даалгав^{2, 3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Б.МӨНХБАТ
С.ЦЭВЭЭНСҮРЭН

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 49/А0571212/БНА 2024/03) ИА-СТА-7123 Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 1-7 дугаар саруудад 6 албан хаагчийн (1-р сард М.Баяржаргал, 5 дугаар сард П.Хүчитбаатар, Ц.Батцэнгэл, Б.Оюун-Эрдэнэ, Э.Цогжаргал, 6 дугаар сард Ц.Батцэнгэл, 9 дүгээр сард Ц.Түвшинбат) нарын нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн дүнгээс илүү мэдээлж, 11 дүгээр сард нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд залруулга хийсний улмаас 813,935.76 (Найман зуун арван гурван мянга есөн зуун гучин таван мянган төгрөг далан зургаан мөнгө)-ийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэн, урд оны ХХОАТ-ын авлага 2,203,040 (Хоёр сая хоёр зуун гурван мянга дөчин төгрөг)-ийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулж тусгасан, суутгаагүй урьдчилгаа цалингийн авлага 50,000 (Тавин мянган төгрөг)-өөр үүссэн, нийт 3,066,975.76 (Гурван сая жаран зургаан мянга есөн зуун далан таван төгрөг далан зургаан мөнгө)-ийн авлагатай гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрхзүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 дахь “Цалин хөлс, шагнал урамшуулал,

5050203

тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх 3,066,975.76 (Гурван сая жаран зургаан мянга есөн зуун далан таван төгрөг далан зургаан мөнгө)-ийн авлагыг холбогдох байгууллагуудаас суутган тооцож, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 04 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын төвийн дарга Б.Алтанчимэг, нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ нарт даалгав^{2,3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Б.МӨНХБАТ
С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудитормын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 88/А05412.12/ВНА-2024/03/НА-СТА-
-ТШЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зоонозын өвчин судлалын төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны зардлаас 1,619,414.89 (Нэг сая зургаан зуун арван есөн мянга дөрвөн зуун арван дөрвөн төгрөг наян есөн мөнгө)-ийн өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.2.2 дахь заалт “Жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн, баталж хэрэгжүүлэх”, 6.4.8 дахь заалт “Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид төсвийг бодитой төлөвлөж, авлага, өр төлбөргүй ажиллах, зөрчлийг арилгаж, нотлох баримтыг FAS системд оруулж, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5040313

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зоонозын өвчин судлалын төвийн дарга Б.Алтанчимэг, нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно